

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжихтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль тогтоомж

2.1.Монгол Улсын мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, өвчингүй, тайван бүс нутаг, хот айл, аж ахуйн нэгжийг тогтоон баталгаажуулах үйл ажиллагаа, мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эдийн ариун цэврийн үзлэг шинжилгээ, мал эмнэлгийн хорио цээрийн хяналт, шалгалттай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

3.2.Энэ хууль зэрлэг амьтдаас мал, тэжээвэр амьтанд дамжин халдварладаг халдварт өвчнийг тандан судлах арга хэмжээнд үйлчилнэ.

3.3.Мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, мал, амьтны тэжээлийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай⁴ хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.

3.4.Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалттай болон мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл, импорт, худалдаатай холбогдон үүсэх харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёо

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. “мал” гэж гэршүүлэн үржүүлж байгаа таван хошуу мал, бусад тэжээвэр амьтныг;

4.1.2.“гэрийн тэжээвэр амьтан” гэж хүний ухамсарт үйл ажиллагаагаар хөгжлийн үйл явцад нь нөлөөлж гэршүүлсэн, ашиг шимийг нь ашиглахаас бусад зорилгоор үржүүлэн ашиглаж байгаа амьтныг;

4.1.3.“зэрлэг амьтан” гэж Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3.2.4-т заасан энэ хуулийн 4.1.1, 4.1.2-т зааснаас бусад амьтныг;

4.1.4.“мэдрэмтгий мал, амьтан” гэж тодорхой нэрийн халдварт өвчнөөр өвчлөх эрсдэлтэй мал, амьтныг;

4.1.5.“мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах” гэж мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчинтэй тэмцэх, бүс, нутгийн халдварт өвчингүй, тайван байдлыг баталгаажуулах цогц үйл ажиллагааг;

4.1.6.“урьдчилан сэргийлэх” гэж өвчний гаралт, тархалтанд нөлөөлж буй

хүчин зүйлийг арилгах зорилгоор хийж байгаа үзлэг, тандалт, халдваргүйтгэл, дархлаажуулалт, нүүлгэн шилжүүлэлт, шилжилт хөдөлгөөний хяналт зэрэг мэргэжлийн үйл ажиллагааг;

4.1.7.“өвчинтэй тэмцэх” гэж халдварт өвчнийг тандах, оношлох, халдварын эх үүсвэрийг илрүүлэх, тархалтын хүрээг тогтоох, дархлаажуулах, эмчлэх, мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хянах, мал эмнэлгийн хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэх, өвчний тархалтыг зогсоох, халдварлалтын түвшинг бууруулах, устгах, өвчний мэдээллийн сан бүрдүүлж ашиглах чиглэлээр хэрэгжүүлж байгаа мал эмнэлгийн цогц арга хэмжээг;

4.1.8.“мал эмнэлгийн үйлчилгээ” гэж мал, амьтны болон нийтийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр мал эмнэлгийн мэргэжлийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг;

4.1.9.“гоц халдварт өвчин” гэж улсын хил хязгаараас үл хамааран богино хугацаанд тархаж хүн, малын эрүүл мэндэд хохирол учруулж, худалдаа, эдийн засгийн байдалд сөргөөр нөлөөлөх өвчнийг;

4.1.10.“шинэ болон дахин сэргэж байгаа өвчин” гэж Монгол Улсад анх удаа оношлогдож байгаа, эсхүл тухайн өвчнөөр тайван, эрүүл байгааг эрх бүхий байгууллагаас баталгаажуулсны дараа дахин гарч байгаа халдварт өвчнийг;

4.1.11.“мал, амьтныг зайлшгүй шаардлагаар төхөөрөх” гэж өвчтэй болон халдварын голомтод байгаа халдвар тараах магадлал бүхий мал, амьтныг холбогдох дүрэм, зааврын дагуу төхөөрч, биологийн хаягдлыг устгахыг;

4.1.12.“мал, амьтныг зайлшгүй шаардлагаар устгах” гэж өвчтэй болон халдварын голомтод байгаа халдвар тараах магадлал бүхий мал, амьтныг холбогдох дүрэм, зааврын дагуу бүрэн устгахыг;

4.1.13.“ийлдсийн сан” гэж халдварт өвчний үүсгэгчийн эсрэг бие махбодод үүссэн эсрэг биемийг хянах, үүсгэгчийн тухай шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээлэл авах зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэрийн тодорхой хэсгээс мал, гэрийн тэжээвэр амьтны төрөл, нас, хүйсийг төлөөлүүлэн тодорхой тооны сорьц авч, жил бүр нөхөн сэлбэдэг цусны ийлдсийн цуглуулгыг;

4.1.14.“малчин” гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасан иргэнийг;

4.1.15.“амьтан маллагч” гэж амьтныг арчлах, тэжээх, болзошгүй аюулаас хамгаалах, хашаа, байр, хорго, хэвтрийг цэвэрлэх үүрэг бүхий иргэнийг;

4.1.16.“тэжээлийн нэмэлт” гэж мал, амьтны ашиг шимийн гарцыг нэмэгдүүлэх үйлчилгээтэй бэлдмэлийг;

4.1.17.“Омгийн сан”

5 дугаар зүйл. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалахад баримтлах зарчим

5.1.Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах талаар дараах үндсэн зарчим баримтална:

5.1.1.мал эмнэлгийн үйлчилгээний мэргэжлийн, шуурхай, бие даасан, нэгдмэл байдлыг хангасан байх;

5.1.2.мал эмнэлгийн үйлчилгээг энэрэнгүй ёс, шинжлэх ухааны мэдлэгт тулгуурлан тэгш хүртээмжтэй хүргэсэн байх;

5.1.3.нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны хориг саадыг арилгахад чиглэсэн байх;

5.1.4.үндэсний онцлог, уламжлалд тулгуурласан, олон улсын жишиг, чиг хандлагад нийцүүлсэн байх;

5.1.5.төр, иргэн, хуулийн этгээд хамтын үйл ажиллагаанд тулгуурласан байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ТОГТОЛЦОО

6 дугаар зүйл.Мал эмнэлгийн алба

6.1.Мал эмнэлгийн албаны удирдах байгууллага нь мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эдийн ариун цэврийн

шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага /цаашид “мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэх/ байна.

6.2.Аймаг, нийслэлд мал эмнэлгийн байгууллага, сум, дүүргийн мал эмнэлгийн тасаг /цаашид “мал эмнэлгийн тасаг” гэх/ болон мал эмнэлгийн үйлчилгээний хувийн хэвшлийн нэгж /цаашид “мал эмнэлгийн үйлчилгээний нэгж” гэх/ ажиллана.

6.3.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мал эмнэлгийн албаны бүх шатны байгууллага, лаборатори, мал эмнэлгийн тасаг болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг өмчийн хэлбэр үл харгалзан мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллана.

6.4.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мал эмнэлгийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, худалдааны чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулж хамтран ажиллана.

6.5.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагыг мал эмнэл зүйн чиглэлээр магистраас доошгүй боловсролын зэрэгтэй, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан малын эмч удирдана.

6.6.Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын бүтцийг Засгийн газраас тогтоосон орон тооны хязгаарт багтаан мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.7.Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын даргыг аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөж, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

6.8.Сум, дүүргийн сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч, улсын байцаагчийг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөж, аймаг нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

6.9.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд мал, амьтны эрүүл мэндийн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зөвлөх үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөл ажиллана.

6.10.Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7 дугаар зүйл. Мал эмнэлгийн лаборатори

7.1.Мал эмнэлгийн оношилгоо, ариун цэврийн лаборатори дараах шатлалаар үйл ажиллагаа явуулна:

7.1.1.улсын мал эмнэлгийн лаборатори төрийн захиргааны байгууллагын харьяанд;

7.1.2.аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лаборатори тухайн шатны нутгийн захиргааны байгууллагын харьяанд;

7.1.3.сум, дүүрэгт хуулийн этгээд хэлбэрээр болон энэ хуулийн 8.5-д заасан эрх бүхий мал эмнэлгийн бүтцэд ажиллах хувийн өмчийн мал эмнэлгийн лаборатори.

7.2.Улсын мал эмнэлгийн лаборатори энэ хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

7.2.1.энэ хуулийн 7.1.2, 7.1.3-т заасан лабораторийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мэргэжил дээшлүүлэх болон стандартын сургалт зохион байгуулах;

7.2.2.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын хангах тухай хуулийн 15.3-т заасны дагуу мал, амьтны эрүүл мэндийн салбарт хамаарах чиг үүргийг хэрэгжүүлэх;

7.2.2.лабораторийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, нийтэд зориулсан мэдээллийг цахим хуудаастаа байршуулах;

7.3.Энэ хуулийн 7.1.2, 7.1.3-т заасан лаборатори энэ хуульд зааснаас гадна харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

7.3.1.итгэмжлэлийн хүрээнд эрүүл ахуй, ариун цэврийн шинжилгээ хийх, мал, амьтны өвчнийг оношлох;

7.3.2.дээд шатны лабораториос ирүүлсэн захиалгын дагуу сорьц авах,

илгээх;

7.3.3. шинжилгээний дүнгээр мэдээллийн сан бүрдүүлж дээд шатны лабораторид хүргүүлэх;

7.4. Малын эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори төрийн захиргааны байгууллагын харьяанд ажиллах бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.4.1. мал эмнэлгийн зориулалтаар шинээр зохион бүтээсэн, үйлдвэрлэсэн, импортолсон эм, биобэлдмэл, эмийн түүхий эдэд сорилт, туршилт, шинжилгээ хийж чанарыг баталгаажуулах, цуцлах;

7.4.2. мал, амьтны эм, бэлдмэл, эмийн түүхий эдэд сорилтын лабораторийн дүгнэлт гаргах;

7.5. Сургалт, эрдэм шинжилгээний байгууллага нь мал эмнэлгийн судалгаа, шинжилгээний лабораторитай байна.

7.6. Энэ хуулийн 7.1.1, 7.5-д заасан лаборатори үндэсний лавлагаа лабораторийн үйл ажиллагаа эрхэлж болно.

7.7. Холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулсан сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн энэ хуулийн 7.1.1, 7.4-т заасан лабораторийн захирлыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга, 7.1.2-т заасан лабораторийн эрхлэгчийг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

7.8. Энэ хуулийн 30.1, 30.4-т заасан мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журам, мал эмнэлгийн үндэсний лавлагаа лабораторийг сонгох журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8 дугаар зүйл. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж

8.1. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж гэж мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх итгэмжлэлтэй малын эмчтэй, стандартын шаардлага хангасан байр, тоног төхөөрөмжтэй, энэ хуульд заасны дагуу мал эмнэлгийн үйлчилгээ эрхэлж байгаа байгууллага, хуулийн этгээдийг хэлнэ.

8.2. Мал эмнэлгийн үйлчилгээний хүрээг дараах байдлаар тогтооно:

8.2.1. ерөнхий мэргэжлийн тусламж, үйлчилгээний;

8.2.2. төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээний;

8.2.3. тусгай мэргэшлийн тусламж, үйлчилгээний.

8.3. Энэ хуулийн 8.2.1-8.2.3-т заасан мал эмнэлгийн үйлчилгээний хүрээ тус бүрд нийцсэн стандарттай байх бөгөөд үйлчилгээ эрхлэх иргэн, хуулийн этгээд дараах байдлаар үйлчилгээний хүрээгээ сонгоно:

8.3.1. бүх төрлийн мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, халдварт өвчинтэй тэмцэх, мал, амьтны гаралтай түүхий эдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйлчилгээ эрхлэх бол ерөнхий мэргэжлийн тусламж, үйлчилгээний;

8.3.2. тодорхой төрлийн мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, халдварт өвчинтэй тэмцэх, тухайн төрлийн мал, амьтны гаралтай түүхий эдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйлчилгээ эрхлэх бол төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээний;

8.3.3. мал эмнэлгийн 5 хүртэл мэргэшлийн чиглэлээр дагнан явуулын болон суурин үйлчилгээ үзүүлэх бол тусгай мэргэшлийн тусламж үйлчилгээний.

8.4. Итгэмжлэлтэй малын эмч, эсхүл итгэмжлэл бүхий малын эмчтэй хөдөлмөрийн гэрээ байгуулсан хуулийн этгээд мал эмнэлгийн үйлчилгээний нэгж байгуулж, харьяалах аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагад бүртгүүлснээр мэргэжлийн үйлчилгээ эрхлэх эрхтэй болно.

8.5. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага шинээр нээх болон шинэчлэн зохион байгуулагдаж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг бүртгэхдээ дараах шаардлагыг хангасан эсэхийг магадлана:

8.5.1. итгэмжлэлтэй малын эмч нь хөдөө орон нутагт үйлчилгээ эрхлэх бол тухайн сумын, дүүргийн нутаг дэвсгэрт үйлчилгээ эрхлэх бол нийслэлийн байнгын оршин суугч байх;

8.5.2. хүсэлт гаргагч этгээд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх хүрээ, үйлчилгээний нэр төрөл, зорилго чиглэлээ тодорхойлсон бизнес төлөвлөгөөтэй байх;

8.5.3. сум, дүүргийн Засаг даргын тодорхойлтоотой байх;

8.5.4.харьяалах сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч тухайн мал эмнэлэг энэ хуулийн 8.5-д заасан холбогдох стандартыг хангасан тухай дүгнэлт гаргасан байх.

8.6.Шинээр нээх, шинэчлэн зохион байгуулагдсан мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг бүртгүүлэх хүсэлт хүлээн авсан аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага ажлын 5 өдөрт багтаан бүртгэнэ, эс зөвшөөрвөл албан бичгээр хариу мэдэгдэнэ.

8.7.Хүсэлт гаргасан этгээд энэ хуулийн 8.5.1-8.5.4-д заасан шаардлагыг хангасан тухай нотлох баримтыг үнэн зөв, бүрэн ирүүлсэн тохиолдолд аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага бүртгэхээс татгалзах эрхгүй.

8.8.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж өөрийн байршиж байгаа сум, дүүргийн нутаг дэвсгэрээс өөр нутаг дэвсгэрт үйлчилгээ үзүүлэх эрхтэй бөгөөд энэ тохиолдолд үйлчилгээ үзүүлэх сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчид хүсэлтээ илэрхийлж, бүртгүүлсэн байна.

8.9.Малчин, мал, амьтны эзэн, амьтан маллагч тухайн нутаг дэвсгэрт байнга болон түр хугацаагаар үйлчилгээ үзүүлж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг өөрөө сонгон үйлчлүүлэх эрхтэй.

8.10.Боловсролын байгууллага болон бусад хуулийн этгээдийн харьяанд сургалтын зориулалттай үйл ажиллагаа эрхэлдэг мал эмнэлгийн үйлчилгээний нэгж энэ хуулийн 8.6-д заасны дагуу бүртгүүлээгүй бол нийтэд үйлчлэх эрхгүй.

8.11.Сум, дүүргийн Засаг дарга, мал эмнэлгийн тасагтай тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжтэй гэрээ байгуулж, төрөөс үзүүлэх мал эмнэлгийн үйлчилгээг гүйцэтгүүлнэ.

8.12.Мал, амьтны халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, зөвлөгөө өгөх чиглэлээр тусгай мэргэшлийн тусламж, үйлчилгээ эрхлэх мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид энэ хуулийн 8.5.1, 8.5.3, 8.8, 8.13.1 дэх заалт хамаарахгүй.

8.13.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж энэ хуулийн 8.2-т заасан үйлчилгээний хамрах хүрээнээс үл хамааран дараах нийтлэг үүрэг хүлээнэ:

8.13.1.сум, дүүргийн Засаг дарга, мал, амьтны өмчлөгч, хариуцагчтай гурвалсан гэрээ байгуулж ажиллах, биелэлтийг хангах;

8.13.2.мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхдээ холбогдох стандарт, техникийн зохицуулалт, журам, зааврыг дагаж мөрдөх;

8.13.3.мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллах;

8.13.4.мал эмнэлгийн үйлчилгээний тайлан, мэдээг хууль, тогтоомжид заасан хугацаанд гаргаж, сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчид хүргүүлэх.

8.14. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага нь тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн талаар төрийн захиргааны байгууллагын даргын баталсан судалгааны хуудасны дагуу анхдагч мэдээллийн сан үүсгэж, түүнийг жил бүр шинэчлэн дээд шатны байгууллагад хүргүүлэх бөгөөд төрийн захиргааны байгууллага бүртгэлийн нэгдсэн сан хөтөлнө.

8.15.Мал эмнэлгийн үйлчилгээний технологийн мөрдөлтөд мал эмнэлгийн тасгийн хяналтын улсын байцаагч хяналт тавих бөгөөд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналтын тайланг хагас жил тутамд аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагад байгууллагад хүргүүлнэ.

8.16.Хяналт, шалгалтын үр дүн, зөрчлийн талаарх мэдээллийг үйлчлүүлэгчид хүргэх ажлыг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага харьяалах сум, дүүргийн Засаг дарга, мал эмнэлгийн тасагтай хамтран зохион байгуулна.

8.17.Дараах тохиолдолд аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг бүртгэлээс хасч үйл ажиллагааг түдгэлзүүлэх ба өмчлөгчид албан бичгээр мэдэгдэнэ;

8.17.1.энэ хуулийн 8.5-д заасан шаардлагыг бүрэн хангахгүй болсон;

8.17.2.мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхдээ гэрээний биелэлттэй холбоотой зөрчлийг гурваас дээш удаа давтан гаргасныг мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч тогтоосон;

8.17.3.мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэхгүйгээр хоёроос дээш жил завсарласан.

8.18.Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг мэдээлэх журмыг Засгийн газрын гишүүн батална.

8.19.Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх итгэмжлэлтэй малын эмч мал эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

8.20.Малын эмч мэргэжилтэй гадаадын иргэнийг тухайн улс орныхоо эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр итгэмжлэлтэй бол Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгж гэрээгээр ажиллуулж болно.

8.21.Төгсөлтийн дараах үргэлжилсэн сургалт явуулах болон малын эмчид итгэмжлэл олгох, малын эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус батална.

8.22.Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, халдварт өвчинтэй тэмцэх, мал, амьтны гаралтай түүхий эдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд оролцож, малын эмчээс өгсөн удирдамж, зааврын дагуу ажил үүрэг гүйцэтгэж байгаа мэргэжлийн үнэмлэхтэй ажилтныг мал эмнэлгийн техникийн ажилтан гэнэ.

8.23.Мал эмнэлгийн техникийн ажилтан нь бие даасан үйл ажиллагаа явуулах эрхгүй.

9 дүгээр зүйл. Малын эмч нарын танхим

9.1.Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, стандарт, шаардлага, малын эмчийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдүүлэх чиг үүрэгтэй нийгэмд үйлчилдэг Малын эмч нарын танхим /төрийн бус байгууллага/ ажиллана.

9.2.Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаанд оролцож байгаа малын эмч бүр танхимын гишүүн байна.

9.3.Малын эмч нар сайн дураараа нэгдэж мэргэжлийн холбоо байгуулж болох бөгөөд мэргэжлийн холбоод нь танхимын үйл ажиллагаанд хорооны эрх эдэлж, үүрэг хүлээх байдлаар оролцож болно.

9.4.Танхим өөрийн үйл ажиллагааг зохицуулсан дүрэмтэй байна.

9.5.Танхим нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.5.1.малын эмч болон мал эмнэлгийн техникийн ажилтны мэргэжил олгох төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагыг тогтоох, сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх болон төгсөлтийн шалгалтын үйл ажиллагаанд оролцох;

9.5.2.малын эмч нарын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

9.5.3.малын эмч болон мал эмнэлгийн техникийн ажилтны мэргэшил, ур чадварын шалгуурыг тогтоох;

9.5.4.мал эмнэлгийн мэргэжлийн үйлчилгээний стандартыг боловсруулахад оролцох;

9.5.5.малын эмчийн мэргэшүүлэх сургалтын хэрэгцээг тодорхойлох, сургалтыг холбогдох сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулах;

9.5.6. малын эмч, мал эмнэлгийн техникийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг баталж хэрэгжилтийг хангуулах;

9.5.7.малын эмчийн мэргэжлийн үйлчилгээтэй холбоотой гомдлыг хянан үзэж дүгнэлт гаргах.

9.2.Танхимын үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэр нь гишүүдийн татвар, үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ МАЛ, АМЬТНЫ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

10 дугаар зүйл. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ

10.1.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг ерөнхий ба тусгай гэсэн хоёр хэлбэрээр зохион байгуулна.

11 дугаар зүйл. Урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ

11.1.Урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ нь мал, амьтны бүх төрлийн өвчнөөс сэргийлэхэд чиглэгдэнэ.

11.2.Урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээнд хашаа, байр, тээврийн хэрэгслийн ариун цэвэр, эрүүл ахуй, орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэл,

шилжилт хөдөлгөөний хяналт хамаарна.

11.3.Энэ хуулийн 11.2-д заасан мал, амьтны хашаа, байрны ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

11.3.1.малчин, амьтан маллагч нь мал, амьтан маллах, ашиглах, эдлэх, тээвэрлэх үедээ хашаа, байр, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн ариун цэвэр, эрүүл ахуйн нийтлэг зааврыг дагаж мөрдөнө.

11.3.2.Энэ хуулийн 11.3.1-д заасан эрүүл ахуй, ариун цэврийн нийтлэг зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

11.4.Энэ хуулийн 11.2-д заасан орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийг хэрэгжүүлэхэд доор дурдсан этгээд дараах үүргийг хүлээнэ:

11.4.1.мал, амьтны өмчлөгч нь малын эмчийн зааварчилгааны дагуу өвөлжөө, хаваржаа болон эрчимжсэн мал аж ахуйн байрны ойр орчимд мал, амьтны хүүр, биологийн хаягдал устгах зориулалтын байгууламж барьж ашиглана;

11.4.2.малчин, амьтан маллагч нь хашаа, байрны ойр орчимд болон ашиглаж буй бэлчээрт энэ хуулийн 11.4.3-т зааснаас бусад шалтгаанаар үхсэн мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулж устгана;

11.4.3.Гамшгаас хамгаалах тухай хуулийн⁷ 4.1.2-д заасан шалтгааны улмаас олноор хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулж устгах, бэлчээр, уст цэг, үерийн жалга, усны эх булгийг цэвэрлэх арга хэмжээг сум, дүүргийн Засаг дарга зохион байгуулна;

11.4.4.хот, суурин газрын нутаг дэвсгэрт мал, амьтан маллаж буй иргэн хуулийн этгээд Эрүүл ахуйн тухай хуулийн 20.1.8-д заасан үүрэг хүлээнэ;

11.4.5.гудамж, талбай, цэцэрлэг болон нийтийн эзэмшлийн газар үхсэн мал, амьтны талаарх иргэд, байгууллагаас мэдээлэл хүлээн авсан харьяалах хорооны Засаг дарга тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа харьяалах мал эмнэлгийн тасаг болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгж /цаашид “гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгж” гэх/-тэй хамтран холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

11.4.6.мал, амьтан үхсэн бол хашаа, байр, орчныг халдваргүйтгэх ажлыг гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгж хийж гүйцэтгэнэ;

11.4.7.мал эмнэлгийн ариутгал, халдваргүйтгэл мал, амьтны хүүр, сэг зэм устгах зааврыг мал амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

11.5.Энэ хуулийн 11.2-д заасан мал, амьтны шилжилт, хөдөлгөөний хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

11.5.1.мал, амьтныг өмчлөгч мал, амьтнаа ялган тэмдэглэж, бүртгэл хөтөлнө;

11.5.2.иргэн, хуулийн этгээд нь мал, амьтныг уралдаан, тэмцээн, үзэсгэлэн, худалдаанд оролцуулах, хээлтүүлэгт ашиглах, төхөөрөх, унах, эдлэх болон бусад зорилгоор тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрээс гадагш шилжилт хөдөлгөөн хийхдээ гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс малын эрүүл мэндийн гэрчилгээ авна;

11.5.3. мал эмнэлгийн үйлчилгээний нэгж энэ хуулийн 11.5.2-т заасан гэрчилгээ олгохдоо дараах шалгуурыг баталгаажуулна:

11.5.3.1.халдварт өвчингүй тайван бүс, нутагт маллаж байсан;

11.5.3.2.халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай дархлаажуулалтад хамрагдсан;

11.5.3.3.тухайн мал, амьтанд халдварт өвчний ерөнхий болон өвөрмөц шинж тэмдэг илрээгүй;

11.5.3.4.хүнсэнд хэрэглэх мал, амьтны хувьд эм, биобэлдмэл хэрэглэснээс хойших хориглох хугацаа өнгөрсөн, эсэх;

11.5.3.5.энэ хуулийн 11.5.1-д заасны дагуу бүртгэл, ялган тэмдэглэгээ хийгдсэн.

11.5.4.иргэн, хуулийн этгээд бусад нутаг дэвсгэрээс мал, амьтан шилжүүлэн авчрах тухайгаа гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид урьдчилан мэдэгдэж, авчирсан даруйдаа харьяалах сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч /цаашид “сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч” гэх/-д бүртгүүлнэ;

11.5.5.малын эрүүл мэндийн гэрчилгээгүй, халдварт өвчний сэжиг илэрсэн мал, амьтныг шилжилт, хөдөлгөөний үед илрүүлсэн, эсхүл хөдөө аж ахуйн чөлөөт бүс,

халдварт өвчнөөс эрүүлжсэнийг баталгаажуулан зарласан нутаг болон бүс рүү нэвтрүүлэх бол мал эмнэлгийн тасгийн хяналтын улсын байцаагчийн шийдвэрээр байцаагч 14-өөс доошгүй хоногийн хугацаанд хорио цээрийн хяналтад оруулан дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

11.5.5.1.мал эмнэлгийн тасгийн улсын байцаагчийн мэдэгдлийг хүлээн авсан иргэн, хуулийн этгээд тээвэрлэж, тууварлаж, унаж, эдэлж яваа мал, амьтнаа мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын талбайд тусгайлан бэлтгэсэн хашаа, байранд оруулна;

11.5.5.2.мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч эмнэл зүйн үзлэг хийж, шаардлагатай тохиолдолд сорьц авч холбогдох мал эмнэлгийн лабораторид хүргүүлнэ;

11.5.5.3.дээж хүлээн авсан лаборатори 7 хоногийн хугацаанд багтаан шинжилгээ хийж, оношилгооны дүгнэлтийг сорьц ирүүлсэн хяналтын цэгт хүргүүлнэ;

11.5.5.4.хорио цээрийн хяналтад байх хугацаанд тухайн мал, амьтан энэ хуулийн 11.5.3.1, 11.5.3.2-т заасан шалгуурыг хангаж байгаа эсэхийг сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч, тархвар зүйчтэй хамтран мөшгин тогтооно;

11.5.5.5.хорио цээрийн хяналтад байгаа мал, амьтан халдварт өвчингүй болох нь нотлогдсон бол мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч малын эрүүл мэндийн гэрчилгээ, эсхүл оношилгооны дүгнэлт олгоно;

11.5.5.6.хорио цээрийн хяналтад байгаа мал, амьтанд халдварт өвчин оношлогдсон бол түүнийг зааврын дагуу эмчлэх, төхөөрөх, эсхүл устгана;

11.5.5.7.мал, амьтныг тээвэрлэх, унаж эдлэхэд хэрэглэсэн тээврийн хэрэгсэл, хашлага, тоног хэрэгслийг халдваргүйтгэх, өвс, тэжээлийн үлдэгдэл, дэвсгэр, чигжээс, биологийн хаягдлыг мал эмнэлгийн тасгийн улсын байцаагчийн хяналт дор устгана.

11.5.6.мал, амьтныг энэ хуулийн 11.5.5-д заасны дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг уг мал, амьтныг унаж эдлэж буй, эсхүл тээвэрлэгч, тууварлагч иргэн, хуулийн этгээд хариуцна.

11.5.7.мал, амьтны дотоод дахь шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулан хорио цээрийн хяналтад байлгах үед мөрдөх журам батлах болон мах бэлтгэл, отор нүүдлийн зорилгоор аймаг дамжиж нэгдсэн журмаар мал туух тууврын зам тогтоох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ;

11.5.8.Энэ хуулийн 11.5.2-т заасан малын эрүүл мэндийн гэрчилгээний загвар, түүнийг хэрэглэх зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

11.5.9.отор хийх зорилгоор сум, дүүргийн нутаг дэвсгэрээс гадагш тээвэрлэж, тууварлах малд гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь эмнэл зүйн үзлэг хийж, энэ хуулийн 11.5.3.1-11.5.3.3-т заасан шалгуурыг хангаж байгаа эсэх талаар сүрэгт эрүүл мэндийн дүгнэлт гаргана.

11.5.10.мал, амьтны шилжилт хөдөлгөөнд дараах зүйлийг хориглоно:

11.5.10.1.сум, дүүргийн мал эмнэлгийн тасаг болон гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид урьдчилан мэдэгдэхгүйгээр бусад сум, дүүргээс мал, амьтан шилжүүлэн авчрах;

11.5.10.2.холбогдох аймаг, нийслэл, эсхүл сум, дүүргийн Засаг даргын хамтын шийдвэрээр отор, нүүлгэн шилжүүлэлт хийхээс бусад тохиолдолд ялган тэмдэглэгээ хийгдээгүй мал, амьтныг тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрээс гадагш тээвэрлэх, тууварлах, уналга, эдэлгээнд ашиглах;

11.5.10.3.мал, амьтныг эрүүл мэндийн гэрчилгээнд заасан мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгт шалгуулахгүй өнгөрөх, тогтоосон замаас өөр замаар тээвэрлэх, тууварлах, зорчих.

11.6.Халдварт өвчингүй, тайван бүс нутаг, хөдөө аж ахуйн чөлөөт бүс рүү нэвтэрч байгаа улсын чанартай авто замыг түшиглэн мал эмнэлгийн хорио цээрийн байнгын ажиллагаатай хяналтын цэг байгуулах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

11.7.Нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах зорилгоор Засаг даргын шийдвэрээр түр, эсхүл байнгын ажиллагаатай мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэг байгуулж болно.

11.8. Энэ хуулийн 11.7-д заасны дагуу байгуулсан хяналтын цэгийн үйл ажиллагааны зардлыг нийслэлийн төсвөөс санхүүжүүлнэ.

12 дугаар зүйл. Урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээ

12.1. Урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээ нь эрсдэл бүхий халдварт өвчний тархалтыг хязгаарлах, халдварлалтын хувийг бууруулахад чиглэгдэх бөгөөд тархвар зүйн судалгаа, дархлаажуулалт, нүүлгэн шилжүүлэлт, шилжилт хөдөлгөөний хяналт хамаарна.

12.2. Энэ хуулийн 12.1-д заасан тархвар зүйн судалгааг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх бөгөөд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

12.2.1. сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч харьяалах нутаг дэвсгэртээ дараах хэлбэрээр мал, амьтны халдварт өвчний тархвар зүйн судалгаа хийж, мал, амьтны эрүүл мэндийн бүртгэлийн анхдагч мэдээллийг бүрдүүлнэ;

12.2.1.1. мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын баталсан тархвар зүйн судалгааны хуудсыг ашиглан мэдээлэл цуглуулах;

12.2.1.2. эрх бүхий байгууллагаас баталж, зөвшөөрсөн маягтын дагуу нэгдсэн хөтөлбөр, аргачлалаар цуглуулж боловсруулсан статистикийн мэдээллийг гаргуулан авах;

12.2.1.3. мал эмнэлгийн үзлэг, лабораторийн шинжилгээ хийлгэх ажил зохион байгуулах.

12.2.2. сум, дүүргээс ирүүлсэн анхдагч мэдээллийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан аймаг, нийслэлийн нутгийн захиргааны байгууллага /цаашид "нутгийн захиргааны байгууллага" гэх/ нэгтгэн газар зүйн мэдээллийн санд оруулж, тухайн нутаг дэвсгэрийн тархвар зүйн зураглал үйлдэнэ;

12.2.3. мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мэдээллийн нэгдсэн сан үүсгэн, улсын хэмжээний тархвар зүйн зураглал үйлдэнэ;

12.2.4. энэ хуулийн 12.2.1, 12.2.2-т заасан мэдээллийг цуглуулах, нэгтгэх, боловсруулах үүрэг хүлээсэн этгээд тухайн мэдээллийг дараагийн шатны байгууллага, албан тушаалтанд дор дурдсан хугацаанд хүргүүлнэ;

12.2.4.1. халдварт өвчин гарсан үед өдөр тутам;

12.2.4.2. халдварт өвчингүй тайван үед улирал тутам.

12.2.5. мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, тайлагнах, хэрэглэгчийг мэдээллээр хангах журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална;

12.2.6. энэ хуулийн 11.2.1-11.2.3-д заасан мэдээллийн сан, тархвар зүйн зураглалыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга хянаж баталгаажуулахаас өмнө хэвлэн нийтлэх, нийтэд мэдээлэх, бусад этгээдэд дамжуулахыг хориглоно.

12.3. Энэ хуулийн 12.1-д заасан дархлаажуулалт нь төлөвлөгөөт, яаралтай гэсэн хоёр хэлбэртэй байна:

12.3.1. өндөр эрсдэлтэй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараа онд хийгдэх төлөвлөгөөт дархлаажуулалтын нэгдсэн төлөвлөгөөг жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

12.3.2. дархлаажуулалтыг яаралтай төлөвлөгөөг тархвар зүйн судалгаа болон лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн дараах тохиолдолд дор дурдсан албан тушаалтан батална:

12.3.2.1. гоц халдварт өвчний үед төрийн захиргааны байгууллагын дарга;

12.3.2.2. энэ хуулийн 8.3.2.1-д зааснаас бусад халдварт өвчний үед нутгийн захиргааны байгууллагын дарга.

12.3.3. дархлаажуулалтыг гэрээт, эсхүл дайчлагдан ажиллаж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгж холбогдох заавар, журмын дагуу хийж гүйцэтгэх бөгөөд аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага болон сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулж хэрэгжилтэд нь хяналт тавина.

12.3.4. дархлаажуулалтын товыг сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч тогтоож, баг, хорооны Засаг дарга малчид, амьтан маллагчдад зарлан мэдээлнэ;

12.3.5.дархлаажуулалт хийх үед малчин, амьтан маллагч, мал, амьтны өмчлөгч дараах үүрэг хүлээнэ:

12.3.5.1.товлосон хугацаанд мал, амьтныг бэлэн байлгаж дархлаажуулалтад бүрэн хамруулах;

12.3.5.2.мал, амьтныг барьж бэхлэн, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, малын эмчийн аюулгүй байдлыг хангах.

12.3.6.дархлаажуулалтын гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага бусад төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулна.

12.4.Энэ хуулийн 12.1-д заасан нүүлгэн шилжүүлэлтийг дараахь байдлаар зохион байгуулна:

12.4.1.энэ хуулийн 18.1.4-т заасан эрүүл бүсэд байгаа мал, амьтныг өвчний хамгаалалтын бүс болон улсын чанартай автозам, төмөр замд ойролцоо байрлах бэлчээр, нутгаас нүүлгэн шилжүүлж болно.

12.4.2.мал, амьтны нягтралыг бууруулах зорилгоор гоц халдварт өвчин гарсан үед мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын, бусад халдварт өвчин гарсан үед аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын даргын саналыг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга нүүлгэн шилжүүлэлт хийх шийдвэр гаргана.

12.4.3.гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь нүүлгэн шилжүүлэх мал, амьтныг эмнэл зүйн үзлэгт нэг бүрчлэн хамруулсны дараа сүрэгт эрүүл мэндийн дүгнэлт гаргана.

12.5.Энэ хуулийн 12.1-д заасан шилжилт, хөдөлгөөний хяналтыг энэ хуулийн 19, 20 дугаар зүйлд заасны дагуу хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох хэлбэрээр хэрэгжүүлнэ.

34.3.12.6.Малчин, амьтан маллагч, мал амьтныг өмчлөгч нь зайлшгүй шаардлагаар хэрэгжүүлэх мал эмнэлгийн арга хэмжээнд малаа тогтоосон хугацаанд хамруулаагүйгээс бусдад учирсан хохирол болон энэ шалтгааны улмаас уг арга хэмжээг нөхөн авч хэрэгжүүлэхэд зарцуулсан зардлыг хариуцна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ МАЛ, АМЬТНЫ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ

13 дугаар зүйл.Заавал мэдээлэх халдварт өвчин

13.1. Заавал мэдээлэх халдварт өвчний шалгуурыг тогтоож, жагсаалтыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн доор дурдсан ангиллаар батална:

13.1.1.бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу тэмцэх, устгах халдварт өвчин;

13.1.2.хяналтын төлөвлөгөөний дагуу тэмцэх, сэргийлэх халдварт өвчин;

13.1.3.энэ хуулийн 13.1.1, 13.1.2-т зааснаас бусад халдварт өвчин;

13.2.Энэ хуулийн 13.1-д заасан халдварт өвчнийг оношлох, мэдээлэх, тэмцэх зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга өвчин тус бүрээр батална.

13.3.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн заавал мэдээлэх өвчний жагсаалтыг шинэчилнэ.

13.4.Доор дурдсан иргэн, хуулийн этгээд, байгууллага өвчний сэжиг илэрсэн үед мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, эсхүл харьяалах сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчид мэдэгдэнэ:

13.4.1.малчин, амьтан маллагч, мал, амьтны өмчлөгч;

13.4.2.үхсэн болон өвчний сэжиг илэрсэн малд үзлэг хийсэн малын эмч;

13.4.3.үзэсгэлэн, худалдаанд ирсэн мал, амьтныг хариуцаж байгаа малын эмч;

13.4.4.мал, амьтан бүхий сургууль, хүрээлэн, лабораторийн удирдлага.

14 дүгээр зүйл. Халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээ

14.1.Мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ улс, бүс, нутгаар хязгаарлалт тогтоох стратегийг баримтална.

14.2.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга халдварт өвчингүй, тайван байдлыг улс, бүс, нутгаар тогтоон зарлан мэдээлнэ.

14.3.Мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх бэлэн байдлын төлөвлөгөө болон хяналтад авах төлөвлөгөө, халдварт өвчингүй, тайван улс, бүс, нутгийг тогтоон зарлах журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

15 дугаар зүйл.Бэлэн байдлын төлөвлөгөө

15.1.Мал эмнэлгийн төрийн болон хувийн хэвшлийн бүх шатны байгууллага, нэгж, мэргэжилтэн нь мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх, гамшгийн улмаас үүсэн хор уршгийг арилгах шуурхай хариу арга хэмжээ (цаашид “шуурхай хариу арга хэмжээ” гэх) хэрэгжүүлэх өдөр тутмын бэлэн байдалд ажиллана.

15.2. Энэ хуулийн 13.1.1-д заасан бэлэн байдлын төлөвлөгөөнд дараах асуудлыг тусгана:

15.2.1.удирдлага, салбар хоорондын харилцаа холбоо, зарлан мэдээлэх систем;

15.2.2.санхүүжилт, санхүүгийн нөөц;

15.2.3.үзлэг, оношилгоо, тархвар зүйн судалгаа, дархлаажуулалт;

15.2.4.хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөний хяналт, хорио цээр, хязгаарлалтын дэглэм;

15.2.5.устгал, нөхөн төлбөр, цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэл;

15.2.6.нийтэд зориулсан мэдээлэл, сургалт сурталчилгаа.

15.3.Бэлэн байдлын төлөвлөгөөнд нийцүүлж аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага, сум, дүүргийн мал эмнэлгийн тасаг тухайн орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх бэлэн байдлын дэд төлөвлөгөөг холбогдох шатны Засаг даргаар батлуулж мөрдөнө.

15.4.Бэлэн байдлын төлөвлөгөөг халдварт өвчний онош тогтоогдсон даруйд мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын мэргэжил, арга зүйн удирдлага дор мал эмнэлгийн бүх шатны байгууллага хэрэгжүүлнэ.

15.5.Аймаг, нийслэл, сум, дүүргийн бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулах аргачлалыг мал, амьтны эрүүл мэндийн болон онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран батална.

15.6.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан Төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн байгууллага шуурхай хариу арга хэмжээ хэрэгжүүлэх үед дайчлан ашиглах дор дурдсан бэлэн байдлын нөөцтэй байна:

15.6.1.яаралтай дуудлага, шуурхай үйлчилгээнд зарцуулах тусгай зориулалтын төсөв;

15.6.2.шаардлагатай тоноглол бүхий автомашин;

15.6.3.шуурхай ажиллагаанд дайчлагдан ажиллах мэргэжлийн баг;

15.6.4.халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээнд хэрэглэх эм, бэлдмэл, халдваргүйтгэлийн бодис, тоног төхөөрөмж, халдвар хамгааллын болон хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл.

15.7.Энэ хуулийн 13.1-д заасан жасаалтад тусгагдаагүй шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын “Хуурай газрын мал амьтны эрүүл мэндийн код”-ыг мөрдөнө.

15.8.Бэлэн байдлын нөөцийг бүрдүүлэх, зарцуулахдаа Улсын нөөцийн тухай хуулийн 15.1.8.-д заасан журмыг баримтална.

16 дугаар зүйл. Халдварт өвчний тандалт, судалгаа

16.1.Мал, амьтны эрүүл мэндийн талаарх иж бүрэн мэдээллийг цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, түгээх болон тэдгээрт үндэслэн хэрэгжүүлэх цогц арга хэмжээг тодорхойлох зорилгоор тандалт, судалгаа хийнэ.

16.2.Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд халдварт өвчний тандалт, судалгаа хийх төлөвлөгөөг Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэж дүгнэлт гаргасны дараа мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга баталж,

хэрэгжилтийг зохион байгуулна.

16.3.Тандалт, судалгааны төлөвлөгөөний хүрээнд хийгдэх тархвар зүйн судалгааг энэ хуулийн 12.2-д заасны дагуу гүйцэтгэнэ.

16.4.Энэ хуулийн 16.2-д заасан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх тандалт, судалгаанд сонгогдсон мал, амьтныг лабораторийн шинжилгээнд хамруулж, ялгах тэмдэглэгээ хийнэ.

16.5.Мал, амьтнаас сорьц авах үед малчин, амьтан маллагч энэ хуулийн 8.3.5.2-д заасан үүрэг хүлээнэ.

16.6.Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лаборатори иргэн, хуулийн этгээдийн захиалгаар тухайн этгээдийн өмчлөл, эзэмшилд байгаа мал, амьтан халдварт өвчингүй тайван байгааг баталгаажуулах шинжилгээ хийж болно.

16.7.Энэ хуулийн 16.6-д заасан шинжилгээний дүнг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга баталгаажуулан тухайн халдварт өвчнөөс эрүүлжсэн нутаг болон бүсийн талаар нийтэд мэдээлнэ.

16.8.Мал, амьтны халдварт өвчнөөс эрүүлжсэн нутаг болон бүсэд мал аж ахуй эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд өөрийн өмчийн мал амьтнаа холбогдох заавар, зөвлөмжид заасны дагуу тогтмол шинжилгээнд хамруулах, шилжилт хөдөлгөөний хяналтын талаарх холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүрэг хүлээнэ.

16.9.Улс, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лаборатори нь өөрийн харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хийсэн тандалт, судалгааны дүнг нэгтгэн мэдээллийн сан бүрдүүлж, тайланг жил бүрийн 1 дүгээр сард багтаан байгууллагынхаа цахим хуудаст байршуулна.

16.10.Тандалт, судалгаа хийх, үр дүнг мэдээлэх журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17 дугаар зүйл. Халдварт өвчний оношилгоо

17.1.Халдварт өвчний өвөрмөц шинж тэмдэг илэрсэн, олон тооны мал гэнэт өвчилсөн, эсхүл хорогдсон тохиолдолд мал, амьтны халдварт өвчний сэжиг илэрсэн гэж үзнэ.

17.2.Халдварт өвчний сэжиг илэрсэн тохиолдолд малчин, амьтан маллагч, мал, амьтны өмчлөгч дараах үүрэг хүлээнэ:

17.2.1.гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид 12 цагийн дотор өгөх;

17.2.2.энэ хуулийн 12.3.5.2-д заасан үүрэг хүлээх;

17.2.3.хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох халдварт өвчин гарсан үед өвчний сэжигтэй мал, амьтныг сүргээс тусгаарлахад зориулан хашаа, байр бэлтгэх, тусгаарлан маллах, арчлах;

17.2.4.малын эмчийн заавар, зөвлөмжийг биелүүлэх.

17.3.Дуудлага хүлээн авсан гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгж дор дурдсан үүрэг хүлээнэ:

17.3.1.өвчний сэжиг илэрсэн хот айл, эрчимжсэн аж ахуйн бүх малд нэн даруй эрүүл мэндийн үзлэг хийж, тархвар зүйн байдлыг тодорхойлж, өвчний эмнэл зүйн шинж тэмдэг болон түргэн оношлуурын дүнг үндэслэн анхны онош тогтоох;

17.3.2.халдварт өвчний сэжигтэй мал, амьтанд тусгайлсан тэмдэг тавьж хяналтад авах;

17.3.3.анхны онош болон малчны хотонд хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар сум, дүүргийн тархвар зүйчид нэн даруй мэдээлэх;

17.3.4.анхны оношийг баталгаажуулах зорилгоор зохих журам, зааврын дагуу сорьц авч 12 цагийн дотор аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораторид хүргүүлэх;

17.3.5.өвчний тархалтын хүрээ нэмэгдэхээс урьдчилан сэргийлж, иргэдэд сэрэмжлүүлэх мэдээ тараах, зөвлөмж өгөх.

17.4.Халдварт өвчний анхны оношийн талаар мэдээлэл хүлээн авсан сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

17.4.1.анхны оношийн талаарх мэдээллийг хүлээн авснаас хойш 2 цагийн дотор сум, дүүргийн Засаг дарга, нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх;

17.4.2.хорио цээр, хязгаарлалт тогтоох халдварт өвчин гарсан нь анхны оношоор тогтоогдсон бол энэ хуулийн 18.1.1, 18.1.2-т заасан голомтын болон сэжигтэй бүсийн заагийг тодорхойлох талаар санал боловсруулах, эдгээр бүсэд багтсан бэлчээрт нутаглаж байгаа айл өрх, мал, амьтны тооны талаар судалгаа хийх, зураглал үйлдэх;

17.4.3.анхны онош тогтоогдсон хот айл, эрчимжсэн аж ахуйн байршлын солбицлыг тогтоох;

17.4.4.хорио цээр, хязгаарлалт тогтоох халдварт өвчин гарсан үед сум, дүүргийн Засаг дарга болон нутгийн захиргааны байгууллагыг тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх өдөр тутмын мэдээллээр хангах.

17.5.Хорио цээр, хязгаарлалт тогтоох халдварт өвчний анхны оношийн талаар мэдээлэл хүлээн авсан сум, аймаг, нийслэлийн Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

17.5.1.энэ хуулийн 19.3.1, 19.3.2, 20.1.1-20.1.3-д заасны дагуу шийдвэр гаргаж халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг зохион байгуулах, хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, эсхүл бүрэн хориглох;

17.5.2.эрсдэлтэй нутаг дэвсгэр болон бэлчээр дэх зэрлэг амьтны байршил, нягтаршил, хөдөлгөөнийг тандах, ажиглан судлах.

17.6.Халдварт өвчний анхны оношийн талаар мэдээлэл хүлээн авсан аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

17.6.1.халдварт өвчнийг оношлох, түүнтэй тэмцэх чиглэлээр сум, дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлж байгаа арга хэмжээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

17.6.2.хорио цээр, хязгаарлалт тогтоох халдварт өвчний анхны оношийн талаарх мэдээллийг хүлээн авснаас хойш 2 цагийн дотор аймаг, нийслэлийн холбогдох байгууллага болон мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргад мэдээлэх;

17.6.3.сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч хүсэлт гаргасан тохиолдолд мэргэжлийн баг томилон ажиллуулах;

17.6.4.аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лаборатори хүлээн авсан сорьцийг шинжлэх, эсхүл дээж хүлээн авснаас хойш 24 цагийн дотор улсын мал эмнэлгийн лабораторид хүргүүлэх;

17.6.5.халдварт өвчний эцсийн оношийг тогтоосон бол 2 цагийн дотор аймаг, нийслэлийн онцгой комисс болон сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчид мэдээлж, өвчний голомтыг устгах хариу арга хэмжээг холбогдох зааврын дагуу хэрэгжүүлэх;

17.6.6.гоц халдварт өвчин гарсан үед мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга болон бусад холбогдох байгууллагыг тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх өдөр тутмын мэдээллээр хангах.

17.7.Сорьц хүлээн авсан улсын мал эмнэлгийн лаборатори дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

17.7.1.хүлээн авсан сорьцинд шинжилгээ хийж, эцсийн болон лавлагаа онош тогтоон дүнг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргад 2 цагийн дотор мэдээлэх;

17.7.2.гоц халдварт өвчин гарсан тохиолдолд эцсийн онош тогтоосноос хойш ажлын 5 өдөрт багтаан олон улсын лавлагаа лабораторид сорьц илгээн онош баталгаажуулах ажлыг зохион байгуулах.

17.7.3.аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лаборатори хүсэлт гаргасан тохиолдолд нарийн мэргэшлийн малын эмч томилон ажиллуулах.

17.8.гоц халдварт өвчин гарсан тохиолдолд эцсийн онош тогтоосноос хойш ажлын 5 өдөрт багтаан олон улсын лавлагаа лабораторид сорьц илгээн онош баталгаажуулах ажлыг зохион байгуулах.

17.9.Халдварт өвчний сэжиг илэрсэн, онош батлагдсан тохиолдолд мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

17.9.1.халдварт өвчнийг оношлох, түүнтэй тэмцэх чиглэлээр сум, дүүрэг, аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлж байгаа арга хэмжээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавьж ажиллах;

17.9.2.гоц халдварт өвчний оношилгооны дүгнэлт, тархвар зүйн судалгаанд тулгуурлан тухайн өвчний голомтыг цомхотгох, устгах хариу арга хэмжээний стратеги боловсруулж хэрэгжүүлэх;

17.9.3.гоц халдварт өвчний эцсийн оношийг баталгаажуулсан тухай мэдээллийг хүлээн авснаас хойш 2 цагийн дотор Улсын онцгой комисст хүргүүлж, нийтэд

мэдээлэх.

17.10.Халдварт өвчний сэжиг илэрсэн, эсхүл онош баталгаажсан тухай мэдээлэл илгээсэн, хүлээн авсан иргэн, байгууллага, албан тушаалтан тухайн цаг хугацаа, огноог тодорхой бичиж тэмдэглэсэн байна.

17.11.Мал, амьтны гоц халдварт өвчний яаралтай мэдээ өгөх журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораторид эцсийн онош тогтоох халдварт өвчний жагсаалтыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга тус тус батална.

17.12.Улсын мал эмнэлгийн лабораторид онош тогтоох мал, амьтны халдварт өвчний жагсаалтыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

18 дугаар зүйл. Халдварт өвчин гарсан үед бүсчлэл тогтоох

18.1.Хорио цээр, хязгаарлалт тогтоох өвчин гарсан үед олон улсын хэмжээнд мөрддөг дүрэм, журам, заавар, бэлчээрийн мал аж ахуй эрхлэх онцлог, өвчин гарсан нутгийн газар зүйн байршил, дэд бүтэц, хүн, мал, амьтны нягтшил, халдварын байдал зэргийг харгалзан дараах бүсийг тогтооно:

18.1.1.өвчин гарсан эрчимжсэн аж ахуй, хот айлтай бэлчээр, ус давхцдаг болон саахалт нутаглаж байгаа хот айл, эрчимжсэн аж ахуйн бэлчээр, нутгийг хамруулан халдварын голомтын бүс;

18.1.2.бэлчээр, ус тусгаар боловч халдварын голомттой ойролцоо нутаглаж байгаа өвчний халдвар тархаж болзошгүй хот айл, эрчимжсэн аж ахуйн бэлчээр нутгийг хамруулан сэжигтэй бүс;

18.1.3.улсын болон олон улсын чанартай авто зам, төмөр зам, мал тууврын зам, хүн, малын шилжилт хөдөлгөөний байдлыг харгалзан сэжигтэй бүсэд багтсан сумын хилийн цэсийн дагуух бэлчээр нутгийг хамруулан хамгаалалтын бүс;

18.1.4.өвчний халдвар дамжаагүй болох нь тархвар зүйн судалгаа, эмнэл зүйн үзлэг, шинжилгээгээр тогтоогдсон, сэжигтэй, болон хамгаалалтын бүсийн заагаас гадна орших бэлчээр нутгийг бүхэлд нь эрүүл бүс.

19 дүгээр зүйл. Хорио цээрийн дэглэм тогтоох, цуцлах

19.1.Богино хугацаанд тархан мал, амьтан, хүн амын эрүүл мэнд, эдийн засагт үлэмж хохирол учруулдаг халдварт өвчин гарсан үед халдварын тархалтыг голомтод нь хязгаарлан зогсоох, устгах зорилгоор голомтын бүсэд хорио цээрийн дэглэм тогтооно.

19.2.Сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч голомтын бүсийн хилийн заагийг тогтоох санал боловсруулан газрын зураг үйлдэж, энэ хуулийн 19.3-т заасан хорио цээрийн дэглэм тогтоох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

19.3.Халдварт өвчний голомтын хүрээнээс хамаарч дараах байгууллага, эрх бүхий албан тушаалтан хорио цээрийн дэглэм тогтоож, цуцална:

19.3.1.нэг сумын нутаг дэвсгэрийг хамарч байгаа бол сумын мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчийн саналыг үндэслэн тухайн сумын Засаг дарга;

19.3.2.хоёр буюу түүнээс дээш сумын нутаг, эсхүл нийслэлийн нутаг дэвсгэр дэх голомтыг нэгтгэх нөхцөл байдал үүссэн, эсхүл нийслэлийн нутаг дэвсгэрийг хамарч байгаа бол аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга;

19.3.3.төмөр зам, олон улсын нисэх буудал, хилийн боомт, хилээр дамжин өнгөрүүлэх цэгийг хамарсан, эсхүл хоёр буюу түүнээс дээш аймгийн нутаг дэвсгэр дэх голомтыг нэгтгэх нөхцөл байдал үүссэн бол мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар.

19.4.Эмнэлгийн яаралтай тусламж авахаас бусад тохиолдолд хорио цээрийн дэглэм тогтоосон голомтын бүсээс гадагш гарах хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглоно.

19.5.Голомтын бүс рүү орох болон бүсийн доторх шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

19.6.Хорио цээрийн дэглэм тогтоох өвчний жагсаалт, хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмыг Засгийн газар батална.

20 дугаар зүйл. Хязгаарлалтын дэглэм тогтоох, цуцлах

20.1.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан Төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, сумын мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчийн саналыг үндэслэн дараах эрх бүхий албан тушаалтан дор дурдснаар хязгаарлалтын дэглэм тогтоож, цуцална:

20.1.1.энэ хуулийн 18.1.2-т заасан сэжигтэй бүс, 18.1.3-т заасан хамгаалалтын бүсэд холбогдох байгууллага, сумын мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчийн саналыг үндэслэн энэ хуулийн 19.3-д заасны дагуу хорио цээрийн дэглэм тогтоох эрх бүхий байгууллага, албан тушаалтан;

20.1.2.голомтын бүсэд хорио цээрийн дэглэм тогтоох санал гаргасан байгууллага тархвар зүйчийн дэглэм бууруулах саналыг үндэслэн тухайн нутаг дэвсгэрийн Засаг дарга, эсхүл Засгийн газар;

20.1.3.энэ хуулийн 20.4-д заасны дагуу баталсан жагсаалтад орсон халдварт өвчин гарсан тохиолдолд сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчийн саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга.

20.2.Хязгаарлалтын дэглэм тогтоосон бүсээс гарах мал, амьтан, мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг хориглоно.

20.3.Зайлшгүй шаардлагаар гарах зорчигч тээврийн хэрэгсэл, хүний хувцас хэрэгслийг шалган нэвтрүүлэх цэг дээр байгуулсан байгууламжид халдваргүйтгэл хийж гаргана.

20.4.Хязгаарлалтын дэглэм тогтоох өвчний жагсаалтыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

21 дүгээр зүйл. Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх арга хэмжээ

21.1.Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед ажиллах малын эмчээр ахлуулсан мэргэжлийн багийг сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр байгуулна.

21.2.Энэ хуулийн 21.1-д заасны дагуу байгуулагдсан мэргэжлийн баг дараах үүрэг хүлээнэ:

21.2.1.мал, амьтанд эмнэл зүйн үзлэг, шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээ хийх;

21.2.2.энэ хуулийн 18.1.4-т заасан эрүүл бүсээс бусад бүсийн мэдрэмтгий мал, амьтныг дархлаажуулах;

21.2.3.өвчний ил шинж тэмдэгтэй болон лабораторийн шинжилгээгээр эерэг урвал үзүүлсэн мал, амьтанд ялгах тэмдэглэгээ хийж, цаашид мөрдөн ажиллах заавраар хангах;

21.2.4.өвчний голомтын, сэжигтэй болон хамгаалалтын бүс дэх хашаа, хороо, уст цэг, малын тоног хэрэгслийг халдваргүйтгэх;

21.2.5.төхөөрсөн мал, амьтны биологийн хаягдал болон мал, амьтны хүүр, сэг зэм, мал, амьтныг устгах цэгийг тогтоох;

21.2.6.энэ хуулийн 21.2.4 болон 21.2.5-д заасан устгалын цэг, 21.3.2-д заасан шалган өнгөрүүлэх цэг дээр хийгдсэн ариутгал, халдваргүйтгэлийн тайланг сум, дүүргийн Засаг дарга, холбогдох мэргэжлийн байгууллагад хүргүүлэх;

21.2.7.сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчийг өвчний цагийн байдлын талаарх мэдээ, мэдээллээр хангах.

21.3.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26.1.3-д заасны дагуу байгуулагдсан мэргэжлийн анги хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

21.3.1.энэ хуулийн 18.1.1-д заасан голомтын бүсийн хилийн зааг дээр таних тэмдэг байрлуулах, тус бүсээс гарах хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, эсхүл бүрэн хориглох арга хэмжээг хэрэгжүүлэх;

21.3.2.энэ хуулийн 18.1.2, 18.1.3-т заасан сэжигтэй болон хамгаалалтын бүсийн авто замын гол чиглэлд шалган өнгөрүүлэх цэг байгуулж, хүн, мал, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавих;

21.3.3.энэ хуулийн 21.1-д заасан мал эмнэлгийн мэргэжлийн багийн ялган тэмдэглэсэн өвчтэй болон өвчний сэжигтэй мал, амьтныг холбогдох зааврын дагуу устгах, эсхүл төхөөрөх, устгалын цэгт хашаа, хамгаалалт барих, сэрэмжлүүлэх тэмдэг байрлуулах;

21.3.4.халдварын голомтын бүсэд оруулах хүнс, бараа, бусад зүйлийг тогтоосон цэгт тусгайлан бэлтгэсэн талбай /тавцан/-д буулгаж сэлгүүлэн хүргүүлэх хэлбэрээр зохион байгуулах.

21.4.Хязгаарлалт, хорио цээрийн дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт дараах үйл ажиллагааг хориглоно:

21.4.1.энэ хуулийн 21.3.2-д заасны дагуу байгуулсан шалган өнгөрүүлэх цэгээс бусад газраар хүн, мал, гэрийн тэжээвэр амьтан, тээврийн хэрэгсэл орох, гарах, дамжин өнгөрөх;

21.4.2.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан удирдах шуурхай бүлгийн зөвшөөрөлгүйгээр бэлчээр, нутаг сэлгэх;

21.4.3.нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, хүн, мал, амьтны бөөгнөрөл бий болгох;

21.4.4.мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээл бэлтгэх, тээвэрлэх, худалдах;

21.4.5.халдварт өвчнөөр өвчилсөн мал, амьтан байрлаж байсан хашаа, байр, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг халдваргүйтгэхээс өмнө дахин ашиглах.

22 дугаар зүйл. Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эрүүлжүүлэх, эмчлэн сэргийлэх арга хэмжээ

22.1.Сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжтэй хамтран энэ хуулийн 12.2.1-д заасан хэлбэрээр жил бүр судалгаа хийж, мал, амьтны шимэгчтэх өвчин /цаашид “шимэгчтэх өвчин” гэх/-ийг тандах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

22.2.Энэ хуулийн 22.1-д заасан судалгааны дүн, албан ёсны статистикийн мэдээллийг үндэслэн сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.

22.3.Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг тарилга, угаалга, туулга, боловсруулалт болон эмийн зааварт заасан аргачлал, арга хэлбэрээр зохион байгуулна.

22.4.Шимэгчтэх өвчнөөс эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх үед малчин, амьтан маллагч, мал, амьтныг өмчлөгч дор дурдсан үүрэг хүлээнэ:

22.4.1.энэ хуулийн 22.2-д заасан төлөвлөгөөний хамрах хүрээнд багтсан шимэгчтэх өвчинд мэдрэмтгий мал, амьтныг гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс тогтоосон хугацаанд бэлэн байлгаж, уг арга хэмжээнд бүрэн хамруулах;

22.4.2.энэ хуулийн 12.3.5.2-д заасны дагуу мал, амьтнаа хаших, барьж бэхлэх зэргээр мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, малын эмчийн аюулгүй байдлыг хангах.

22.5.Шимэгчтэх өвчний тархалт, халдварлалтын байдал улсын эдийн засаг, нийтийн эрүүл эрүүл мэндэд аюул учруулах хэмжээнд хүрснийг мал эмнэлгийн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага тогтоосон бол энэ хуулийн 6.9-д заасан мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн өвчинтэй тэмцэх үндэсний төлөвлөгөө боловсруулж, мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулан хэрэгжилтийг зохион байгуулна.

22.6.Шимэгчтэх өвчнийг тандах судалгааны хуудас болон шимэгчтэх өвчинтэй тэмцэх зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

22.7.Шимэгчтэх өвчнийг тандах судалгааны дүн, энэ хуулийн 22.2, 22.5 -д заасан төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч нэгтгэж, дараа оны 1 дүгээр улиралд багтаан аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагад хүргүүлнэ.

23 дугаар зүйл. Мал, амьтны халдваргүй өвчний оношилгоо, эмчилгээ

23.1.Сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын баталсан судалгааны хуудсыг ашиглан цуглуулсан мэдээлэл болон албан ёсны статистикийн мэдээллийг нэгтгэн тухайн нутаг дэвсгэрт тохиолдож байгаа халдваргүй өвчний анхдагч мэдээллийн сан үүсгэнэ.

23.2.Мал амьтны халдваргүй өвчний анхдагч мэдээллийг гамшиг тохиолдсон үед 7 хоног тутам, тайван үед хагас жил тутам нутгийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

23.3.Малчин, амьтан маллагч өөрийн өмчлөл, эзэмшил дэх мал, амьтанд өдөр тутам ажиглалт хийж, өвчин эмгэг, гэмтэл тохиолдсон үед анхны тусламж үзүүлэх бөгөөд энэ тухай гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид заавал мэдээлнэ.

23.4.Гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгж халдваргүй өвчний оношийг эмнэл зүйн шинж тэмдэг, шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн тогтоож, малчин, амьтан маллагч, мал, амьтны өмчлөгчийн зөвшөөрснөөр эмчилгээ хийнэ.

23.5.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид харьяалах нутаг дэвсгэрийн мал, амьтанд тохиолдож байгаа халдваргүй өвчин, түүнээс үүсэж болох эрсдэл, хор хохирол, сэргийлэх арга хэмжээний талаар малчин, амьтан маллагч, мал, амьтныг өмчлөгчид улирал тутам зөвлөгөө өгнө.

23.6.Шалтгаан нь тодорхойгүй халдваргүй өвчний тархалтын хүрээ, эмчлэх арга, эдийн засгийн хор хохирол, хүн, мал, амьтны эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөг тогтоох чиглэлээр мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас захиалан гүйцэтгүүлсэн шинжлэх ухаан, технологийн төслийн үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд зориулан захиалагч эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

23.7.Гамшгийн улмаас олон тооны мал үхсэн тохиолдолд хор уршгийг арилгахад чиглэсэн арга хэмжээг Гамшгийн тухай хуульд заасны дагуу холбогдох шатны Засаг дарга зохион байгуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ

24 дүгээр зүйл. Нийтийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн мал эмнэлгийн үйлчилгээ

24.1.Мал эмнэлгийн алба нь нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

24.1.1.мал, амьтнаас хүнд халдварладаг өвчингүй, тайван байдлыг хадгалах, өвчин гарсан үед тэмцэх;

24.1.2.мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эдийг бэлтгэх, тээвэрлэх, хадгалах, борлуулах үе шатанд аюулгүй байдлыг баталгаажуулах.

25 дугаар зүйл. Мал, амьтнаас хүнд халдварладаг өвчинтэй тэмцэх, хяналтад авах, эрүүлжүүлэх арга хэмжээ

25.1.Мал, амьтнаас хүнд халдварладаг өвчин /цаашид “зооноз өвчин” гэх/-тэй тэмцэх, хяналтад авах, арга хэмжээг энэ хуулийн 3, 4 дүгээр бүлгийн холбогдох заалтын дагуу хэрэгжүүлнэ.

25.2.Зооноз өвчнөөс нийтийн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах, удирдлагаар хангах үүрэг бүхий орон тооны бус зөвлөл /цаашид “хамтарсан зөвлөл” гэх/-тэй байна. Хамтарсан зөвлөлийг эрүүл мэндийн болон мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд байгуулж, ажиллах журмыг батална.

25.3.Хамтарсан зөвлөл нь эрүүл мэндийн болон мал эмнэлгийн ажлын хэсгүүдтэй байж болно.

25.4.Зооноз өвчнийг хяналтад авах стратеги төлөвлөгөө, төслийг эрүүл мэндийн болон мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталж хэрэгжүүлнэ.

25.5.Аймаг, нийслэлийн Засаг дарга зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүлжүүлэх үйл ажиллагааг Эрүүл мэндийн тухай хуулийн⁹ 11.1.2-д заасны дагуу хэрэгжүүлнэ.

25.6.Зооноз өвчний халдвар авах эрсдэл бүхий иргэдэд тухайн өвчний талаар мэдлэг олгох сургалтыг мал эмнэлгийн болон эрүүл мэндийн бүх шатны байгууллага, мэргэжилтэн хамтран зохион байгуулна.

25.7.Хот, суурин газрын нутаг дэвсгэрт мал, амьтан, тэдгээрийн гаралтай хүнсний бус түүхий эдийн худалдаа эрхлэх байршлыг тухайн шатны Засаг дарга тогтооно.

25.8.энэ хуулийн 25.7-д заасан худалдаа эрхлэх иргэн, хуулийн этгээд мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын баталсан мал, эмнэлэг, ариун цэврийн шаардлагыг дагаж мөрдөнө.

26 дугаар зүйл. Мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эдийн аюулгүй байдлыг хангах

26.1. Мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

26.1.1. мал, амьтны тэжээлийн аюулгүй байдлыг хангах;

26.1.2. мал, амьтны гаралтай хүнсний түүхий эдийн эм, бэлдмэл, пестицидийн үлдэгдлийг хянах;

26.1.3. мал, амьтны гаралтай түүхий эдэд ариун цэврийн магадлан шинжилгээ хийх.

27 дугаар зүйл. Мал, амьтны тэжээлийн нэмэлтийн хяналт

27.1. Мал, амьтны тэжээлийн аюулгүй байдлыг хянах чиглэлээр мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

27.1.1. мал, амьтны тэжээлийн нэмэлтийг улсын бүртгэлд бүртгэх;

27.1.2. улсын бүртгэлд бүртгэгдээгүй, эсхүл олон улсын хэрэглээнээс хасагдсан тэжээлийн нэмэлтийг зах зээлээс эгүүлэн татах.

27.2. Мал, амьтны тэжээлийн нэмэлтийг бүртгэх журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

27.3. Мал, амьтны тэжээлийн нэмэлт бүтээгдэхүүнийг бүртгэх, импортын зөвшөөрөл олгох журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

27.4. Мал, амьтны тэжээлийн аюулгүй байдлын хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн холбогдох заалтаар зохицуулна.

28 дугаар зүйл. Мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд дэх эм, бэлдмэлийн үлдэгдлийн хяналт

28.1. Мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд дэх эм, бэлдмэлийн үлдэгдлийн хяналтыг Засгийн газраас баталсан үндэсний төлөвлөгөөний дагуу Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

28.2. Малын эмч болон малчин, амьтан маллагч эм, бэлдмэл хэрэглэсэн тухай бүрд мал, амьтны эрүүл мэндийн бүртгэлийн дэвтэрт тэмдэглэл үйлдэнэ.

28.3. Мал, амьтны эм, биобэлдмэлийн зохистой хэрэглээг хэвшүүлэх сургалт, сурталчилгааг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага, сум, дүүргийн мал эмнэлгийн тасаг, гэрээт мал эмнэлэг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулна.

28.4. Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч иргэн баталгаагүй эм, биобэлдмэл худалдан авах, малын эмчийн зааварчилгаагүйгээр хэрэглэхийг хориглоно.

29 дүгээр зүйл. Мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эдийн ариун цэвэр, эрүүл ахуй

29.1. Мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эдэд баталгаа гаргахдаа үзлэг хийсэн малын эмч, эсхүл энэ хуулийн 7.1.3-т заасан лаборатори дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

29.1.1. өвчингүй, тайван нутагт маллаж байсан, шаардлагатай дархлаажуулалтад хамрагдсан, мал, амьтанд эм, бэлдмэл, пестицид хэрэглэснээс хойш хүлээх хугацаа дууссан эсэхийг магадлах;

29.1.2. мал, төхөөрөх цэг, байр, орчинд халдваргүйтгэл хийх, эрүүл ахуйн шаардлага хангуулах;

29.1.3. мал, амьтныг төхөөрөхийн өмнөх болон дараах үзлэг хийх;

29.1.4. түүхий мах, өндөг, сүүний шинэлэг байдлыг холбогдох стандартад заасан аргачлалын дагуу шинжилж тогтоох;

29.1.5. холбогдох журам, заавар, стандартад заасан бусад шаардлага.

29.2.Энэ хуулийн 29.1-д заасан үйл ажиллагааны үр дүн, мал, амьтны эрүүл мэндийн бүртгэлийн дэвтэрийн баталгаажилт зэргийг үндэслэн мал эмнэлгийн үйлчилгээний нэгж ариун цэврийн гэрчилгээ олгоно.

29.3.Хадгалалт, тээвэрлэлтийн явцад мал, амьтны гаралтай хүнсний түүхий эдийн гадна байдалд нь өөрчлөлт орж, шинэлэг байдлаа алдсан, эсхүл бохирдсон бол нийтийн хэрэгцээнд худалдахын өмнө лабораторийн магадлан шинжилгээ хийнэ.

29.4.Магадлан шинжилгээгээр ариун цэврийн шаардлага хангаж байгаа нь тогтоогдвол лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээ олгоно.

29.5.Ариун цэврийн болон лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээний загвар, гэрчилгээ олгох зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

29.6.Мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эдийг тээвэрлэгч энэ хуулийн 29.2-т заасан гэрчилгээг аваагүй бол сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч мал эмнэлгийн хяналтын цэгт 14 хүртэл хоног саатуулж, дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

29.6.1.иргэн, хуулийн этгээдэд тээвэрлэж яваа түүхий эдээ мал эмнэлгийн хяналтын цэгийн тусгайлан бэлтгэсэн агуулах, саравч, тавцанд буулгах мэдэгдэл өгөх;

29.6.2.нарийвчилсан үзлэг хийж, шаардлагатай тохиолдолд сорьц авч холбогдох мал эмнэлгийн лабораторид хүргүүлэх;

29.6.3.Энэ хуулийн 29.6.2-т заасан сорьц хүлээн авсан лаборатори 7 хоногийн хугацаанд багтаан шинжилгээ хийж, дүгнэлтийг сорьц ирүүлсэн сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн улсын байцаагчид хүргүүлэх;

29.6.4.нарийвчилсан үзлэгийн дүн, лабораторийн магадлан шинжилгээний дүгнэлтээр ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа нь тогтоогдсон бол сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч магадлан шинжилгээний гэрчилгээ олгох;

29.6.5.хорио цээрийн хяналтад байгаа түүхий эд ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад нийцэхгүй болох нь тогтоогдсон бол тухайн түүхий эд, түүний сав баглаа боодол, хог, хаягдлыг зааврын дагуу устгах;

29.6.6.тээврийн хэрэгсэл, тээвэрлэлтэд хэрэглэсэн тоног төхөөрөмжийг халдваргүйжүүлэх.

29.7.Мал, амьтны гаралтай хүнсний үйлдвэрлэл эрхлэгчид Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7.1, 9.1 дэх хэсгийг тус тус дагаж мөрдөнө.

29.8.Түүхий сүүг үйлдвэр, цехэд нийлүүлэх, худалдах үед мөрдөх ариун цэвэр, эрүүл ахуйн зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

29.9.Худалдааны зориулалтаар мах бэлтгэж байгаа боловсруулах үйлдвэр, нядалгааны цехэд улсын байцаагч ажиллан мал төхөөрөхийн өмнөх болон дараах үзлэг, шинжилгээ хийж, аюулгүй байдлыг баталгаажуулна.

29.10.Энэ хуулийн 29.9-д заасны дагуу хийсэн үзлэг, шинжилгээгээр халдварт өвчний сэжиг илэрвэл сорьц авч лабораторид илгээх ба харьяалах сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчид мэдээлнэ.

29.11.Мэдээлэл хүлээн авсан сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч энэ хуулийн 17.4-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

29.12.Мал бэлтгэх, тууварлах, тээвэрлэх, үйлдвэрт хүлээн авах үеийн мал эмнэлэг хорио цээрийн журам, мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийх, баталгааны тэмдэг хэрэглэх журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус батална.

29.13.Хэрэглэгч нь Хүнсний тухай хуулийн¹⁰ 15 дугаар зүйлд зааснаас гадна мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг дараах оролцоогоор дэмжинэ:

29.13.1.ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангахгүй, битүүмжлэлгүй, хөргүүргүй тээврийн хэрэгсэл, зах, худалдааны төв, хүнсний дэлгүүр, лангуу, мухлаг, ил задгай газар худалдаалагдаж байгаа мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдаж авахгүй байх;

29.13.2.ариун цэврийн, эсхүл магадлан шинжилгээний гэрчилгээгүй бүтээгдэхүүнийг худалдан авах, тээвэрлэх, зөөвөрлөхөөс татгалзах;

29.13.3.энэ хуулийн 29.13.1, 29.13.2-д заасан зөрчил илэрсэн тухай мал

эмнэлгийн үйлчилгээний нэгж, холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх.

29.14.Энэ хуулийн 29.6-д заасны дагуу хорио цээрийн хяналтад байлгах хугацаанд гарсан зардлыг тухайн мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэгч иргэн, хуулийн этгээд хариуцна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САНХҮҮЖИЛТ

30 дугаар зүйл. Улсын төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээ

30.1.Улсын төсвийн санхүүжилтээр дараа онд хэрэгжүүлэх мал эмнэлгийн арга хэмжээний төлөвлөгөөний төслийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага доор дурдсан тайлан, мэдээллийг үндэслэн боловсруулж, жил бүрийн 5 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ:

30.1.1.өмнөх онд хэрэгжүүлсэн мониторингийн дүгнэлт болон холбогдох судалгааны тайлан;

30.1.2.албан ёсны статистикийн мэдээлэл;

30.1.3.энэ хуулийн 12.2-т заасны дагуу хийж гүйцэтгэсэн тархвар зүйн судалгааны дүн.

30.2.Мал эмнэлгийн үйлчилгээний дараах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:

30.2.1.энэ хуулийн 15.6-д заасан арга хэмжээний зардал;

30.2.2.энэ хуулийн 13.1.1-д заасан жагсаалтад орсон халдварт өвчинтэй тэмцэх, устгах арга хэмжээний дараах зардал:

30.2.2.1.вакцин, оношлуур, халдваргүйтгэлийн бэлдмэл, хамгаалах хувцас, хэрэгслийн үнэ;

30.2.2.2.тандалт, судалгаа, лабораторийн шинжилгээ, дархлаажуулалт хийх, мэдээллийн сан байгуулж ажиллуулах үйл ажиллагааны зардал;

30.2.2.3.эмнэл зүйн үзлэг, тарилга, халдваргүйтгэл хийх, лабораторийн шинжилгээнд зориулан сорьц авах болон мал эмнэлгийн бусад үйлчилгээний хөлс;

30.2.2.4.зайлшгүй шаардлагаар төхөөрсөн малын тухайн орон нутаг дахь жишиг үнийн 40 хувь, гоц халдварт өвчний улмаас зайлшгүй шаардлагаар устгасан малын тухайн орон нутаг дахь жишиг үнийн 90 хувьтай тэнцэх нөхөн төлбөр.

30.2.3.Дараах халдварт болон шимэгчтэх өвчнийг тандах, эрт илрүүлэхэд шаардагдах үйл ажиллагааны зардал, эмнэл зүйн үзлэг хийх, лабораторийн шинжилгээнд зориулан сорьц авах үйлчилгээний хөлс, оношлуурын үнэ:

30.2.3.1.шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчин;

30.2.3.2.энэ хуулийн 13.1.2, 13.1.3-д заасан жагсаалтад орсон халдварт өвчин;

30.2.3.3.энэ хуулийн 22.5-д заасан шимэгчтэх өвчин.

30.2.4.энэ хуулийн 4.1.13-т заасны дагуу мал, амьтны ийлдсийн сан бүрдүүлэх, түүнийг хадгалах, ашиглахад шаардагдах зардал;

30.2.5.гоц халдварт өвчин гарсан үед энэ хуулийн 21.1, 21.3-т заасны дагуу байгуулагдсан мэргэжлийн баг, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд дайчлагдан ажилласан малын эмч, мэргэжилтэн, албан хаагч, иргэдэд олгох дараах зардал:

30.2.5.1.ердийн үеийнхээс 3 дахин нэмэгдүүлсэн томилолтын зардал;

30.2.5.2.албан үүргээ гүйцэтгэж байгаад амь насаа алдсан иргэний ар гэрт олгох 36 сарын цалинтай тэнцэх тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж.

30.3.Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын норматив, улсын төсөвт байгууллагатай шууд гэрээ байгуулах хэлбэрээр эм, бэлдмэл худалдан авах үнэ тарифыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

30.4.Энэ хуулийн 30.2.2.4, 31.2.2.2-д заасан нөхөн төлбөр олгоход баримтлах жишиг үнийг статистикийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тогтооно.

30.5.Улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн арга хэмжээний эдийн засгийн үр ашгийг тооцох судалгааг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

30.6.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага доор дурдсан үйл ажиллагааны санхүүжилтийг дараах төрийн захиргааны төв байгууллагатай хамтран шийдвэрлэнэ:

30.6.1.энэ хуулийн 25.4-д заасан төлөвлөгөөнд заасан арга хэмжээний зардлыг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай;

30.6.2.энэ хуулийн 3.2-т заасны дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай.

31 дүгээр зүйл. Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээ

31.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн санхүүжилтээр дараа онд хэрэгжүүлэх мал эмнэлгийн арга хэмжээний төлөвлөгөөний төслийг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага, сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч энэ хуулийн 30.1.1, 30.1.2, 30.1.3-т заасан тайлан, мэдээллийг үндэслэн боловсруулж, жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан тухайн шатны Засаг даргад хүргүүлнэ.

31.2.Мал эмнэлгийн үйлчилгээний дараах зардлыг аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлнэ:

31.2.1.энэ хуулийн 15.3-д заасан дэд төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардал;

31.2.2.энэ хуулийн 13.1.2-д заасан жагсаалтад орсон халдварт өвчинтэй тэмцэх, устгах арга хэмжээний дараах зардал:

31.2.2.1.энэ хуулийн 30.2.2.1-30.2.2.3-д заасан зардал;

31.2.2.2.зайлшгүй шаардлагаар төхөөрсөн малын тухайн орон нутаг дахь жишиг үнийн 40 хувьтай тэнцэх нөхөн төлбөр.

31.2.3.хорио цээрийн дэглэм тогтоох өвчний жагсаалтад орсон гоц халдварт өвчнөөс бусад халдварт өвчин гарсан үед тухайн шатны Засаг даргын шийдвэрээр хэрэгжүүлж байгаа голомтыг устгах, хяналтад авах арга хэмжээний зардал;

31.2.4.харьяалах нутаг дэвсгэр дэх мал, амьтныг эрүүлжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан хөтөлбөр, төсөл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал.

31.3.Мал эмнэлгийн үйлчилгээний дараах зардлыг сум, дүүргийн төсвөөс санхүүжүүлнэ:

31.3.1. энэ хуулийн 15 .3-т заасан дэд төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардал;

31.3.2.дуудлагын дагуу ажиллаж анхны онош тогтоох үйл ажиллагааны тээвэр, шатахууны зардал, халдварт өвчин гарсан үед хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах халдваргүйтгэлийн бэлдмэлийн үнэ;

31.3.3.харьяалах нутаг дэвсгэр дэх мал, амьтныг эрүүлжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан хөтөлбөр, төсөл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал.

31.4.Малчин, мал, амьтны өмчлөгч, амьтан маллагч хууль тогтоомжид заасан үүргээ биелүүлээгүйг эрх бүхий байгууллага, албан тушаалтан тогтоосон бол энэ хуулийн 30.2.2.4, 31.2.2.2-т заасан нөхөн төлбөрийг олгохгүй.

32 дугаар зүйл. Иргэн, хуулийн этгээдээс санхүүжүүлэх арга хэмжээ

32.1.Мал эмнэлгийн үйлчилгээтэй холбогдсон дараах зардлыг иргэн, хуулийн этгээдээс санхүүжүүлнэ:

32.1.1.амьтны хүрээлэнгийн, циркийн, лабораторийн болон гэрийн тэжээвэр амьтны эрүүл мэндийг хамгаалахад шаардагдах мал эмнэлгийн үйлчилгээний бүх зардал;

32.1.2.халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүлжүүлэх арга хэмжээний улсын төсөв, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр зааснаас бусад зардал;

32.1.3.шимэгчтэх өвчинтэй тэмцэх, эрүүлжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа энэ хуулийн 30.2.3.3, 31.2.4, 31.3.3-т зааснаас бусад арга хэмжээний зардал;

32.1.4.халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх үйлчилгээний энэ хуулийн 31.2.4, 31.3.3-т зааснаас бусад бүх зардал;

32.1.5.мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, аюулгүй байдлыг баталгаажуулахтай холбогдсон бүх зардал;

32.1.6.холбогдох хууль, тогтоомжид заасан бусад зардал.

**ДОЛООДУГААР БҮЛЭГ
БУСАД**

33 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

33.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

33.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

34 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

34.1.Энэ хуулийг оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг